



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Төрийн жинхэнэ албан хаагчийн
ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, 9.8 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоолын 2 дахь заалт, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэдэх “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, яамны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл (П.Дэлгэрмаа)-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ч.ЗОЛБАЯР

995555

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны
10 дугаар сарын 20-ны өдрийн 1/97 дугаартай
тушаалын 1 дүгээр хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга:

П.Дэлгэрмаа
(Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга)

Зөвлөлийн гишүүд:

Д.Батбаяр
(Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Нийтийн мэдээллийн
дэд бүтцийн хэлтсийн дарга)

Э.Бямбасүрэн
(Бодлого, төлөвлөлтийн газрын Ахлах
шинжээч)

М.Оролзод
(Кибер аюулгүй байдлын бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын
Шинжээч)

Ч.Болор-Эрдэнэ
(Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Ахлах мэргэжилтэн)

Зөвлөлийн нарийн бичгийн
дарга:

Д.Ариунзул
(Төрийн захиргааны удирдлагын газрын
Хүний нөөцийн бодлого хариуцсан
шинжээч)

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны
10 дугаар сарын 20 -ны өдрийн 197 дугаартай
тушаалын 2 дугаар хавсралт

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч (цаашид “албан хаагч” гэх)-ийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг хэлэлцэж эцэслэн дүгнэх, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагаа, шийдвэр нь Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, яамны “Хөдөлмөрийн дотоод журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг

2.1. Зөвлөл нь албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын шинжтэй гэж үзвэл сахилгын хариуцлага хүлээлгэх тухай эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэх, харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

2.2. Зөвлөл нь байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус байна.

2.3. Зөвлөл нь дарга, гишүүд гэсэн нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнийг яамны албан хаагчдын саналыг үндэслэн Төрийн нарийн бичгийн дарга 3 жилийн хугацаагаар томилно.

2.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд ёс зүйн болон сахилгын хариуцлага хүлээж байгаагүй төрийн жинхэнэ албан хаагч ажиллана.

2.5. Зөвлөлийн дарга, гишүүний томилгоот хугацаанаас өмнө орон гарвал Төрийн нарийн бичгийн дарга нөхөн томилох арга хэмжээг 10 өдрийн дотор зохион байгуулна. Шинээр томилогдсон дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

2.6. Зөвлөлийн дарга дараах чиг үүрэгтэй ажиллана: